



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2009 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах,  
түүнд хяналт тавих журам” шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлах тухай 81 дүгээр тогтоолыг энэ тогтоолын 1-д заасан журам үйлчилж эхэлмэгц хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоол батлагдсантай холбогдуулан нөхөн төлбөрийн хэлбэлзлийн нөөц сан, учирч болзошгүй эрсдэлийн нөөц сан, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан, нэхэмжилсэн боловч олгогдоогүй хохирлын нөөц сан, орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн үлдэгдлийг хувь оролцоогүй гэрээний нөөц санд нэгтгэн байршуулахыг “Нэйшнл лайф даатгал” ХХК (Б.Энхтунгалаг)-д үүрэг болгосугай.

5.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН НӨӨЦ САНГ БҮРДҮҮЛЭХ,  
ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

**НЭГ.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 14.2.3, 51, 80 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, урт хугацааны даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.2.1.“Хувь оролцоотой (participating) гэрээ” гэж гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээг;

1.2.2.“Хувь оролцоогүй (non participating) гэрээ” гэж гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах талаар гэрээнд заагаагүй урт хугацааны даатгалын гэрээг;

1.2.3.“Хөрөнгө оруулалттай холбоотой (investment linked) гэрээ” гэж даатгалын хураамжийн зохих хэсэг нь тодорхой хөрөнгө оруулалтад даатгуулагчийн хүсэл сонирхол болон гэрээнд заасан нөхцлийн дагуу байршдаг урт хугацааны даатгалын гэрээг.

**ХОЁР.Даатгалын нөөц санг бүрдүүлэх**

2.1.Даатгагч нь даатгалын дараах нөөц сангуудтай байна:

2.1.1.Хувь оролцоотой гэрээний нөөц сан;

2.1.2.Хувь оролцоогүй гэрээний нөөц сан;

2.1.3.Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан.

2.2.Энэ журмын 2.1-д заасан нөөц сан нь ирээдүйд төлөх нөхөн төлбөр болон зардлын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрээс даатгуулагчийн төлөх даатгалын нийт хураамжийн өнөөгийн үнэ цэнийг хассан зөрүүгээр тодорхойлогдоно.

2.3. Даатгагч нь нөөц санг цэвэр хураамжийн орлого болон хөрөнгө оруулалтын орлогоос бүрдүүлэх бөгөөд цэвэр хураамжийн орлогыг даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалд төлсөн хураамжийг хасч тооцно.[/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

2.4. Давхар даатгалын компани нь “Standard and Poors”-ийн “А” ба түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй компани байна.

2.5. Энэ журмын 2.1-д заасан нөөц сан нь даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сангаас бүрдэнэ. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

2.6. Даатгалын багц бүтээгдэхүүнийг нөхцөл тус бүрээр задалж нөөц сангийн тооцооллыг хийнэ. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

2.7. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо даатгагчийн мөрдөж байгаа насжилтын хүснэгтэд үндэслэнэ. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг энэ журмын 3.2-т зааснаар тооцно. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

2.8. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/](#)

#### **ГУРАВ. Урт хугацааны даатгалын актуар тооцооллод ашиглах хүчин зүйлс**

3.1. Хорооноос эрх авсан урт хугацааны даатгалын актуарч нь нөөц сангийн актуар тооцооллыг хийх бөгөөд хүүгийн түвшин, нас баралтын түвшин, гэрээ цуцлалтын түвшин, зардлын түвшинг тус тус харгалзаж үзсэн байна.

3.2. Хүүгийн түвшинг тогтооход эрсдэлгүй хүүгийн түвшин, инфляц, эрсдэлийн хураамжийг үндэслэж дараах байдлаар тооцно:

3.2.1. Эрсдэлгүй хүүгийн түвшинг Засгийн газрын бондын хүүгийн түвшинтэй ижлээр тооцно;

3.2.2. Инфляцыг Монголбанкнаас тухайн жилд зарласан зорилтот түвшинтэй ижлээр тооцно;

3.2.3. Эрсдэлийн хураамжийг даатгалын актуарч тооцоолно.

3.3. Нас баралтын түвшинг Үндэсний статистикийн хорооноос гаргасан нас баралтын хүснэгтийг (mortality table) ашиглан тооцоолно.

3.3.1. Нас баралтын хүснэгтэд наслалтын тохируулгыг тооцно. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн амьдрах хугацаа нь өөр өөр байдагт үндэслэн даатгалын гэрээнд эмэгтэй хүний төлөх даатгалын хураамж нь даатгалын ижил нөхцөлтийн гэрээтэй 3-5 насаар залуу эрэгтэй хүний төлөх хураамжтай адилаар тооцогдоно.

3.4. Гэрээ цуцлалтын түвшинг нь даатгагч, даатгуулагчийн аль нэгний саналын дагуу даатгалын гэрээ дуусахаас өмнө цуцлах хэмжээг харгалзан тооцно.

3.5.Зардлын түвшинг тухайн даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд гарч болох бүхий л зардлуудын хүрээнд тооцоолж тогтооно.

3.6.Даатгагч нь дээрх үзүүлэлтүүдийг анх тогтоох ба өөрчлөлт оруулах тухай бүрд болон нөөц сангийн тооцоололд албан ёсоор ашиглахаасаа өмнө Хороонд мэдэгдэнэ.

#### **ДӨРӨВ.Даатгалын нөөц санг зарцуулах**

4.1.Даатгалын тохиолдол болсон үед хувь оролцоотой гэрээ, хувь оролцоогүй гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ тус бүрд холбогдох нөөц сангаас нь даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

4.2.Урт хугацааны даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд даатгалын нөөц сангийн хэмжээ хүрэлцэхгүй болсон тохиолдолд даатгагч нь дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг ашиглах, зарцуулах талаар Хороонд мэдэгдэж зөвшөөрөл авна.

4.3.Даатгалын нөөц санг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд нөөц сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэх, сольж зарцуулахыг хориглоно.

#### **ТАВ.Даатгалын нөөц санд тавих хяналт**

5.1.Даатгагчийн даатгалын нөөц сангийн тооцооллыг Хорооноос урт хугацааны даатгалын актуарчийн эрх авсан актуарч баталгаажуулсан байна.

5.2. Хорооноос эрх авсан актуарч нь даатгалын нөөц сангийн тооцооллын тайланг энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар, нөөц сангийн бүрдүүлэлтийн тайланг хоёрдугаар хавсралтаар тус тус улирал бүр гаргаж Хороонд ирүүлнэ. [/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)


5.3.Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд Хорооны хянан шалгагч байнга хяналт тавина.

5.4.Даатгагч даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг Хорооноос баталсан маягтын дагуу улирал бүр гаргаж Хороонд ирүүлнэ.

#### **ЗУРГАА.Хариуцлага**

6.1.Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд журмыг зөрчсөн тохиолдолд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Урьд хугацааны даатгалын нөөцийн санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 1 дүгээр хавсралт



УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН КОМПАНИЙН (.....)\* НӨӨЦ САНГИЙН ТООЦООЛЛЫН ТАЙЛАН

Даатгагчийн нэр \_\_\_\_\_

20... оны ... сарын ... өдөр  
Тайлант хугацаа

Даатгалын хураамжийн хүүгийн түвшин \_\_\_\_\_

| Даатгалын хэлбэр              | Даатгалын бүтээгдэхүүн | Даатгуулагчийн тоо | Ирээдүйн нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ | Ирээдүйн даатгалын хураамжийн өнөөгийн үнэ цэнэ | Нөөц сан |
|-------------------------------|------------------------|--------------------|--|---|----------|
| 1. Хугацаат амьдралын даатгал | 1.1. ...               |                    |  |   |          |
|                               | 1.2. ...               |                    |  |   |          |
|                               | ...                    |                    |  |   |          |
|                               | ГЭХ МЭТ                |                    |  |   |          |
| Дун                           |                        |                    |  |   |          |
| 2. Насан туршийн даатгал      | 2.1. ...               |                    |  |   |          |
|                               | 2.2. ...               |                    |  |   |          |
|                               | ...                    |                    |  |   |          |
|                               | ГЭХ МЭТ                |                    |  |   |          |
| Дун                           |                        |                    |  |   |          |
| ...                           |                        |                    |  |   |          |
| ГЭХ МЭТ                       |                        |                    |  |   |          |
| <b>Нийт дун</b>               |                        |                    |  |   |          |

\*- Хувь оролцоотой гэрээний, Хувь оролцоогүй гэрээний, Хөрөнгө оруулалттай гэрээний нөөц сан тус бүрээр гаргана.

ТАНИЛЦСАН

"....." ХХК-ийн  
гүйцэтгэх захирал

тамга тэмдэг

\_\_\_\_\_ (гарын үсэг)

\_\_\_\_\_ (овог нэр)

ТООЦООЛОЛТ ХИЙСЭН

Эрх бүхий актуарч

\_\_\_\_\_ (гарын үсэг)

\_\_\_\_\_ (овог нэр)

Насжилтын хүснэгтийг хавсаргана.

/Энэхүү хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмсэн/



Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Урт хугацааны даатгалын нөөцийн саяг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар хавсралт

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН КОМПАНИЙН (.....)\* НӨӨЦ САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр

20... оны ... сарын ... өдөр  
Тайлант хугацаа

(төгрөгөөр)

УХА0410 5043239

| Даатгалын хэлбэр              | Даатгалын бүтээгдэхүүн | Нөөцийн сангийн эхний үлдэгдэл | Нөхөн төлбөр                       |                                    | Давхар даатгагчаар төлүүлсэн нөхөн төлбөр | Даатгалын цэвэр хураамжаас нэмэгдсэн | Хөрөнгө оруулалтын орлогоос нэмэгдсэн | Нөөц сангийн эцсийн үлдэгдэл /9=3-4-5+6+7+8/ |
|-------------------------------|------------------------|--------------------------------|------------------------------------|------------------------------------|---|--------------------------------------|---------------------------------------|--|
|                               |                        |                                | Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр | Гэрээ цуцлалтын хураамжийн буцаалт |   |                                      |                                       |  |
| 1                             | 2                      | 3                              | 4                                  | 5                                  | 6   | 7                                    | 8                                     | 9  |
| 1. Хугацаат амьдралын даатгал | 1.1. ...               |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | 1.2. ...               |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | ...                    |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | ГЭХ МЭТ                |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| Дун                           |                        |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| 2. Насан туршийн даатгал      | 2.1. ...               |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | 2.2. ...               |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | ...                    |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
|                               | ГЭХ МЭТ                |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| Дун                           |                        |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| ...                           |                        |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| ГЭХ МЭТ                       |                        |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |
| Нийт дүн                      |                        |                                |                                    |                                    |   |                                      |                                       |  |

\*- Хувь оролцоотой гэрээний, Хувь оролцоогүй гэрээний, Хөрөнгө оруулалттай гэрээний нөөц сан тус бүрээр гаргана.

ТАНИЛЦСАН

"....." ХХК-ийн  
гүйцэтгэх захирал

тамга тэмдэг

(гарын үсэг)

(овог нэр)

ТООЦООЛОЛТ ХИЙСЭН

Эрх бүхий актуарч

(гарын үсэг)

(овог нэр)

/Энэхүү хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолоор нэмсэн/